

ХАНБОГД СУМЫН УДИРДЛАГА, МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Их булаг

2015 оны 6-р сарын 8

Та бүхэнд Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (CAO) байгууллагын оролцоотой маргааныг шийдвэрлэх Малчдын төлөөлөгчид, Сумын удирдлага болон Оюу толгой компанийн хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын тухай мэдээлдэг билээ. Энэ удаагийн хурал 2015 оны 6-р сарын 8-ны өдөр Ханбогд сумын Иргэдийн хөгжлийн төвд хийгдсэн ба уулзалтын тойм мэдээг та бүхэнд хүргүүлж байна.

Энэ удаагийн уулзалтын гол зорилго нь Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой (ОТ) компани малчдад тулгамдаж буй асуудлаар зөвшилцөх Гурван талт зөвлөл байгуулах Харилцан ойлголцлын санамж бичиг, Зөвлөлийн дүрмийн төслийг эцэслэх, Хөндлөнгийн шинжээчдийн II шатны ажлыг гүйцэтгэх багийн хувилбар, Олон талт мэргэжлийн шинжээчдийн багийг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийн төсөл болон Европын Сэргээн босголт хөгжлийн банкны гомдол барагдуулах албанаас ирүүлсэн албан бичигт хариу өгөх талаар хэлэлцэх байлаа.

Уулзалтыг CAO-ын газрын зуучлагч чиглүүлж, Ханбогд сумын Засаг даргын орлогч Х.Отгонжаргал тэргүүтэй Ханбогд сумын захиргааны төлөөлөл, Малчдын төлөөлөл болон Оюу толгой компанийн төлөөллүүд оролцлоо.

Удаа дараа хэлэлцэж зөвшилцсөний үндсэн дээр талууд Ханбогд сум, Малчдын төлөөлөгчид болон ОТ-н хооронд Гурван талт зөвлөлийг албан ёсоор байгуулан Харилцан ойлгоцлын санамж бичигт Ханбогд сумыг төлөөлөн сумын ИТХ-н дарга болон Засаг дарга, Малчдын төлөөлөл 5-н малчин, Оюу Толгойг төлөөлөн Нийгмийн харилцааны Ерөнхий менежер нар гарын үсэг зурж Гурван талт зөвлөл албан ёсоор байгууллаа.

Мөн энэ удаагийн уулзалтад Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газрын дэд ерөнхийлөгч Освальдо Гратакос биечлэн ирж оролцлоо.

Гурван Талт Зөвлөл